

**САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ 2025 ОНЫ
01 ДҮГЭЭР САРЫН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

№	Хийгдэх ажил	Хүрэх үр дүн	Хугацаа	Биелэлт
1	Хугацаатай мэдээ, тайлан гаргах	Төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг	Дараа сарын 02-ны дотор	2025 оны 1-р сарын байдлаар манай байгууллага 310,000.0 мянган төгрөгийн санхүүжилтийг авч 270,839.0 мянган төгрөгийг зарцуулж, 39,161.0 мянган төгрөг тайлант хугацаанд зарцуулагдаагүй байна.
		Шилэн дансны мэдээллийг нэгдсэн цахим санд оруулах	Дараа сарын 08-ны дотор	Тайлант хугацаанд оруулбал зохих 17 мэдээллийг хуулийн хугацаанд нь оруулсан.
		Татварын тайланг гаргаж хүргүүлэх	01 сарын 25-ны дотор	2024 оны 4-р улирлын татварын тайлангуудыг хуулийн хугацаанд илгээж баталгаажуулсан.
		Жилийн эцсийн санхүүгийн тайланг гарган хүргүүлэх	01 сарын 25-ны дотор	2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг гарган Төрийн аудитын газарт түүврийн аудит хийлгүүлэхээр 2025.01.24-ны өдөр хүргүүлсэн
		Ниймгийн даатгалын тайлан гаргаж, хүргүүлэх	Дараа сарын 05-ны дотор	12-р сарын НДШ-ийн тайланг хуулийн хугацаанд илгээж, тайлагнасан.
2	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангуулах	Хуулийн хэрэгжилт хангагдана	1 сар	Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасны дагуу аймгийн төсөвт, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нийт 50 байгууллагын шилэн дансны мэдээллийг цахим хуудсанд үнэн зөв болон цаг хугацаандаа оруулж байгаа эсэхэд хяналт тавьж ажилладаг. Тайлант хугацаанд шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт 97,6 хувьтай. Энэ нь өмнөх жилийн мөн үеэс 5,3%-иар өсчээ.
3	Мэдээллийн ил тод байдлыг хангах	Мэдээллийн ил тод байдал хангагдах	1 сар	Мэдээллийн ил тод байдлыг хангаж, ойлгомжтой байлгах үүднээс байгууллагын веб хуудас болон самбарт 5 мэдээ мэдээллийг байршуулсан. Байгууллагын facebook хуудас https://www.facebook.com/profile.php?id=100090091147081/ -аар 6 мэдээллийг иргэд олон нийтэд түгээж ажиллалаа.
4	Бусад ажил	Байгууллагын үйл ажиллагаа сайжирна.	1 сар	Аймгийн удирдах ажилчдын шуурхай зөвлөгөөний 1 удаагийн хурлаас өгсөн 1 үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь хүргүүлсэн.

				Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга С.Амарсайхан 2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр "Бүсчилсэн хөгжлийн бодлого Говьсүмбэр аймаг" уулзалт хэлэлцүүлгийг зохион байгуулж, тус уулзалтад Санхүүгийн хяналт дотоод аудитын албаны хаагчид хамрагдлаа. 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр Аймгийн Засаг дарга аймгийн нийт төрийн байгууллагуудын хэвлэл мэдээлэл, цахим хариуцсан мэргэжилтнүүд болон хувийн хэвлэл мэдээллийн байгууллагууд, сэтгүүлчдийн уулзалт зөвлөгөөнд хамрагдсан. Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг гаргаж ХШҮ-д хүргүүлсэн. 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр "И-Монгол Академи" УТУГ-аас зохион байгуулсан "ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН НЭГДСЭН ЦАХИМ ХУУДАС ТАНИЛЦУУЛАХ" сургалтад хамрагдсан.
5	“УС-ДУ” ОНӨААТҮГазрын 2023-2024.09 сар хүртлэх үйл ажиллагаанд дотоод аудит хийх	Байгууллагын үйл ажиллагаа сайжирна	1 сар	“УС-ДУ” ОНӨААТҮГазрын 2023-2024.09 сар хүртлэх үйл ажиллагаанд дотоод аудит хийгдэж байна. Аудитын явц 95 хувьтай үргэлжилж байна.
6	Ус-Ду ОНӨҮГ-ын 2021-2023 оны баримтанд санхүүгийн хяналт шалгалт хийх	Байгууллагын үйл ажиллагаа сайжирна	1 сар	Байгууллагын 2024 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу аймгийн Засаг даргын баталсан 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 06 дугаар удирдамжаар тус газрын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгдэж байна. Шалгалтын явц 90%-тай явж байна.
7	Шивээговь сумын хоршоо хөгжүүлэх сангийн 2023 оны үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт хийх	Байгууллагын үйл ажиллагаа сайжирна	1 сар	Байгууллагын 2024 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу аймгийн Засаг даргын баталсан 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 07 дугаар удирдамжаар тус газрын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн. Шалгалтаар нийт 17,680.1 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, 4,013.0 мянган төгрөгийн улсын ахлах байцаагчийн хугацаатай албан шаардлага, 13,667.1 мянган төгрөгийн зөвлөмж хүргүүлсэн. Албан шаардлагын хариу ирүүлэх хугацаа болоогүй.
8	Цөм сүрэг үржлийн төвийн 2018-2024 оны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх	Байгууллагын үйл ажиллагаа сайжирна	1 сар	Тус байгууллагын үйл ажиллагаанд хяналот шалгалт хийгдэж байна. Шалгалтын явц 70 хувьтай.

9	Байгууллагын 2024 оны үйл ажиллагааны тайланг Сангийн яаманд хүргүүлэх	Хуулийн хэрэгжилт хангагдана	1 сар	Байгууллагын 2024 оны үйл ажиллагааны тоон болон бичмэл тайланг 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 08 дугаартай албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн.
---	--	------------------------------------	-------	---

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

Нягтлан бодогч:



Б.Аззаяа